УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2022 оны 11 сарын 09 өдөр Дугаар А/228 Улаанбаатар хот

Санхүүжилт батлах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 65 дугаар тогтоол, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар хэсгийн 3.1.10 -т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтийн эзэмшлийн гадна талбайн тохижилт, тохижилтын хийц эдлэл тоног төхөөрөмж, нарийн хийц бүхий уран бүтээлийн ажлын төлөвлөлт, хөдөлгөөнт дүрс, гурван хэмжээст загвар зураг гаргах ажлын зардлыг хавсралт ёсоор баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтэс (С.Эрдэнэсайхан)-т үүрэг болгосугай.

3. Дээрх ажилд шаардлагатай зардлыг хот тохижилтын бусад зардлаас санхүүжүүлэхийг Төсвийн санхүүжилт, тайлагналт, бүртгэл хариуцсан Ахлах нягтлан бодогч (Ч.Алтанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (С.Жамъяндорж)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ГАНБОЛД

C:\Users\User\Desktop\УЖ 12\doc 2022\тушаал.docx

111031125

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2022 оны 11 дүгаар сарын 09-нө өдрийн
А/228 дугаар тушаалын хавсралт

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГАДНА ТАЛБАЙН ТОХИЖИЛТ,
ТОХИЖИЛТЫН ХИЙЦ ЭДЛЭЛ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ,
НАРИЙН ХИЙЦ БҮХИЙ УРАН БҮТЭЭЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨДӨЛГӨӨНТ ДҮРС, ГУРВАН ХЭМЖЭЭСТ
ЗАГВАР ЗУРАГ ГАРГАХ АЖЛЫН ЗАРДАЛ

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал байршил	Төсөвт өртөг
1	Нийтийн эзэмшлийн гадна талбайн тохижилт, тохижилтын хийц эдлэл тоног төхөөрөмж, нарийн хийц бүхий уран бүтээлийн ажлын төлөвлөлт, хөдөлгөөнт дүрс, гурван хэмжээст загвар зураг гаргах ажил	20.000,000
Нийт дүн		20.000,000